

“Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал
Д.Тогтохсүрэн танаа

ХАБХ-Т
Зөвшөөрөв.
2024.09.25

Тендерийн шийдвэр гаргах хугацааг
сунгуулах тухай

2024 оны 9 дүгээр сарын 25

“Монголросцветмет” ТӨҮГ-ын 2024 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу зарлагдсан “Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх” ажлын МРЦМ/20240101332 дугаартай тендерийн Багц №1 ба 2-т гомдол гарсны дагуу Сангийн яамны 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 03/7427 тоотой тухайн багцуудын үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдрөөс түдгэлзүүлсэн тухай мэдэгдсэн.

Гаргасан гомдлыг хянан үзээд Сангийн яамнаас 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 03/7706 тоотой ирүүлснийг Худалдан авалт, борлуулалтын хэлтсийн тендер хариуцсан ажилтнуудаас 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр хүлээн авсан.

Тухайн гомдлыг хянасан албан тоотой “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтын дагуу захиалагчийн 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 1/1833, 1/1834 тоот шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлээд тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн байна.

Иймд тухайн тендер шалгаруулалтын Багц №1 болон Багц №2-т хамаарах үнэлгээг дахин хийх шаардлагатай болсон тул “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дах заалтад “ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн 59.10-т заасан шийдвэр гаргасан нөхцөлд.. захиалагч энэ хуулийн 24.1-т заасан хугацааг ажлын 15 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно” тендерийн хугацааг сунгаж өгнө үү.

Хавсралт:

Сангийн яамны 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 03/7427 тоот -1 хуудас

Сангийн яамны 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 03/7706 тоотой- 6 хуудас

Үнэлгээний хорооны дарга

Нарийн бичиг



П.Хангал

Б.Батсайхан



Захирагч-г уламжлах нь:
ТӨНӨ-ХАБХ-Уурьтг даалгаа гаргуу ажлын
15 хажуу өдөр ажиллагаа цахил састбуудыг
орчуулж өгөх шаардлага санхүүгийн
ХАБХ
2024.09.25



“МОНГОЛПРОСПЕКТМЕТ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 09. 09 № 03/7427
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан МРЦМ/20240101332 дугаартай “Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх” тендер шалгаруулалтын 1 болон 2 дугаар багцад оролцсон “Агар од инженеринг” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ



9766013337



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.09.17 № 03/7706

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МРЦМ/20240101332 дугаартай “Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх” тендер шалгаруулалтын 1 болон 2 дугаар багцад оролцсон “Агар од инженеринг” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Агар од инженеринг” ХХК-ийн ирүүлсэн гомдолд тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй, мөн тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Хөрс транс” ХХК болон тендер шалгаруулалтын 2 дугаар багцад шалгарсан “БАСИС” ХХК тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэхгүй тул хянан үзэхийг хүссэн байна.

I. Гомдолд дурдсаны дагуу “Агар од инженеринг” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Геологи-хайгуулын өрмийн ажлын инженер (заагдсан хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэх)-2 хүн” гэж заасан байна.

“Агар од инженеринг” ХХК худалдан авах ажиллагааны цахим системийн хүний нөөц хэсэгт өрмийн инженерээр М.Мөнхбаяр, Ж.Хоролдулам нарыг тус тус санал болгосон байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.13-т “Оролцогчоос ирүүлсэн тендер энэ журмын 2.3.6-д заасны дагуу цахим системийн холбогдох талбарт оруулсан

9766014817

мэдээлэлтэй зөрвөл цахим системийн мэдээллийг баримтална.” гэж заасны дагуу “Агар од инженеринг” ХХК-ийн худалдан авах ажиллагааны цахим системээр санал болгосон хүний нөөцийн мэдээллийг хянан үзээгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Батлагдсан төсөвт /багцын/ өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1 удаа. Ижил төстэй ажил гэж “Геологи хайгуулын өрөмдлөг, геологи хайгуулын ажил болон ГХА-ын дүнгээр нөөцийн тайлан боловсруулсан ажил”-ыг ойлгоно. Геологи хайгуулын ажил, нөөцийн тайлан боловсруулах чиглэлийн ажил гүйцэтгэсэн туршлага: 2 жилээс багагүй байх” гэж, мөн ТШЗ 19.2-т “2022, 2023 онд ижил төстэй хийж гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл” гэж тус тус заасан байна.

“Агар од инженеринг” ХХК тендерт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Монлид трейд” ХХК-тай байгуулсан 700.00 сая төгрөгийн “Цохилтот өрөмдлөгийн ажил гүйцэтгэх гэрээ”, 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн гэрээ дүгнэсэн тухай акт, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Баян Эрдэс” ХХК-тай байгуулсан 565.0 сая төгрөгийн “Цохилтот өрөмдлөгийн ажил гүйцэтгэх гэрээ”, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн гэрээ дүгнэсэн акт, мөн дээрх гэрээнүүдийн талаар V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээллийг тус тус ирүүлсэн байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэлд “...Захиалагчийн тодорхойлолт гаргасан “Баян эрдэс” ХХК болон “Монлид трейд” ХХК-аас “Монлид трейд” ХХК-ийн 2024.08.12-ны өдрийн 24/31 тоот, “Баян эрдэс” ХХК-ийн 2024.08.13-ны өдрийн 24/43 тоот тодорхойлолтуудыг болон хэрэгжүүлсэн гэрээтэй холбогдуулсан лавлагаа авах нь зүйтэй гэж үзэж байна. Тодруулгын хүсэлтийг бэлтгэн “Баян эрдэс” ХХК болон “Монлид трейд” ХХК-д аж ахуйн нэгжийн лавлагааны систем дэх электрон шуудан болон утсаар электрон хаягийн мэдээлэл авч лавлагаа хүссэн албан тоотыг илгээсэн. Тодруулгын дагуу “Баян эрдэс” ХХК-аас 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн гэрээний хуулбарыг хянан үзэхэд гэрээнд дарагдсан тамганы дардас нь “Монлид трейд” ХХК-ийн тамга дарагдсан байгааг анхааралдаа авав. Энэ нь тендерт ирүүлсэн “Баян эрдэс” ХХК-тай байгуулсан гэрээний дардаснаас өөр байгаа болно. Багц 1, 2-т санал ирүүлсэн “Агар од инженеринг” ХХК-ийн ижил төстэй ажлын туршлагын талаар мэдүүлсэн гэрээ болон захиалагчийн тодорхойлолт нь тендерийн үнэлгээний баримт, материалын шаардлагыг хангахгүй байна...” гэж дурдсан байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 13.3-т “Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.” гэж заасан байх бөгөөд хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу “Агар од инженеринг” ХХК-ийн ижил төстэй ажилд санал болгосон гэрээ бодитоор хэрэгжсэн эсэх талаар тодруулж үнэлгээ хийсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

II. Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Хөрс транс” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт хөдөлмөрийн гэрээ, намтар ирүүлэхийг заагаагүй тул “Хөрс транс” ХХК тендерт санал болгосон ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Геологи хайгуулын ажил гүйцэтгэх, нөөцийн тооцоо хийх чадвартай боловсон хүчинтэй байх, үүнээс геологич нь мэргэшсэн зэргээс дээш зэрэгтэй байх. Голлох инженерүүдийн төгссөн сургуулийн диплом, (зөвлөх, мэргэшсэн инженерийн гэрчилгээ), нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлнэ.” гэж заасан байна.

2.1.“Хөрс транс” ХХК тендерт геологи хайгуулын ажлыг удирдах ажилтнаар Ж.Ган-Очирыг, геологич (Геологи хайгуулын ажил, технологийн судалгааны ажлыг гардан гүйцэтгэх)-оор Э.Доржготов, Б.Тамир нарыг санал болгосон байх бөгөөд Ж.Ган-Очир, Б.Тамир нарын хүчин төгөлдөр зөвлөх, мэргэшсэн инженерийн гэрчилгээ ирүүлсэн эсэхийг захиалагч хянан үзээгүй байна.

2.2.“Хөрс транс” ХХК тендерт геологи-хайгуулын өрмийн ажлын инженер (заагдсан хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэх)-ээр Б.Галсандорж, Г.Хатанбаатар нарыг санал болгосон байх бөгөөд Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх...2.5.3.хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.” гэж заасны дагуу захиалагч дипломын мэдээлэл, нийгмийн даатгалын лавлагааг цахим системээр татаж, хянан үзэх ажиллагааг хийлгүйгээр шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Батлагдсан төсөвт /багцын/ өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1 удаа. Ижил төстэй ажил гэж “Геологи хайгуулын өрөмдлөг, геологи хайгуулын ажил болон ГХА-ын дүнгээр нөөцийн тайлан боловсруулсан ажил”-ыг ойлгоно. Геологи хайгуулын ажил, нөөцийн тайлан боловсруулах чиглэлийн ажил гүйцэтгэсэн туршлага: 2 жилээс багагүй байх” гэж, мөн ТШЗ 19.2-т “2022, 2023 онд ижил төстэй хийж гүйцэтгэсэн

геологи хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл” гэж тус тус заасан байна.

“Хөрс транс” ХХК тендерт 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1 удаа ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаарх мэдээлэл ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1, ТШЗ 19.2-т заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. 1. Геологи хайгуулын өрмийн машин. Дээр дурдсан машин механизм нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийн эсвэл түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн хийсэн байх бөгөөд дуусах хугацаа нь ажил гүйцэтгэж дуусах хугацаа хүртэл хүчинтэй байна. Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах бичиг баримтаар нотолно. Үүнд: 1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар 2. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн түрээсийн гэрээ” гэж заасан байна.

“Хөрс транс” ХХК тендерт CS 1300 өрмийн машин санал болгосон байх бөгөөд техникийн гэрчилгээний хуулбар ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

5. “Хөрс транс” ХХК тендерт усны цистерн санал болгож ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. 2. Усны цистерн. Дээр дурдсан машин механизм нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийн эсвэл түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн хийсэн байх бөгөөд дуусах хугацаа нь ажил гүйцэтгэж дуусах хугацаа хүртэл хүчинтэй байна. Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах бичиг баримтаар нотолно. Үүнд: 1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар 2. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн түрээсийн гэрээ” гэх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

III. Гомдолд дурдсаны дагуу тендер шалгаруулалтын 2 дугаар багцад шалгарсан “БАСИС” ХХК болон “Тайхаржин майнинг” ХХК-ийн түншлэлийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.4-т “Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус

бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Батлагдсан төсөвт /багцын/ өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1 удаа. Ижил төстэй ажил гэж “Геологи хайгуулын ерөмдлөг, геологи хайгуулын ажил болон ГХА-ын дүнгээр нөөцийн тайлан боловсруулсан ажил”-ыг ойлгоно. Геологи хайгуулын ажил, нөөцийн тайлан боловсруулах чиглэлийн ажил гүйцэтгэсэн туршлага: 2 жилээс багагүй байх” гэж, ТШЗ 19.2-т “2022, 2023 онд ижил төстэй хийж гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл” гэж тус тус заасан байна.

“БАСИС” ХХК 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр “Тайхаржин майнинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

“БАСИС” ХХК тендерт 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр “Саммит эксплорэйшн” ХХК-тай 308,800,950.0 төгрөгөөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, гэрээ дүгнэсэн акт ирүүлсэн боловч түншлэлийн гишүүн “Тайхаржин майнинг” ХХК-ийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаарх мэдээлэл ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.4, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. 2. Усны цистерн. Дээр дурдсан машин механизм нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийн эсвэл түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн хийсэн байх бөгөөд дуусах хугацаа нь ажил гүйцэтгэж дуусах хугацаа хүртэл хүчинтэй байна. Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах бичиг баримтаар нотолно. Үүнд: 1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар 2. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн түрээсийн гэрээ” гэж заасан байна.

“БАСИС” ХХК болон “Тайхаржин майнинг” ХХК-ийн түншлэл худалдан авах ажиллагааны цахим системийн тоног төхөөрөмж хэсэгт 2591УНТ улсын дугаартай тээврийн хэрэгслийг усны машинаар санал болгосон боловч захиалагч Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.3.хуульд заасан эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл (энгийн болон тусгай)-ийн мэдээлэл, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, дээд боловсролын дипломын мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг бодит цагийн горимоор дамжуулдаг, өдөр тутам өөрчлөгддөггүй мэдээлэл.” гэж заасны дагуу хянан үзээгүй байна.

3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Геологи хайгуулын ажил гүйцэтгэх, нөөцийн тооцоо хийх чадвартай боловсон хүчинтэй байх, үүнээс геологич нь мэргэшсэн зэргээс дээш зэрэгтэй байх. Зөвлөхийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод төвшин: Геологич (Геологи хайгуулын ажлыг удирдах, технологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, түүний дүнгээр нөөцийн тайлан боловсруулах)-1 хүн. Голлох инженерүүдийн төгссөн сургуулийн диплом, (зөвлөх, мэргэшсэн инженерийн гэрчилгээ), нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлнэ.” гэж заасан байна.

“БАСИС” ХХК болон “Тайхаржин майнинг” ХХК-ийн түншлэл худалдан авах ажиллагааны цахим системийн хүний нөөц хэсэгт төслийн ахлагчаар Г.Мөнхзулыг санал болгосон байх бөгөөд зөвлөх, мэргэшсэн инженерийн гэрчилгээг ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 1/1833, 1/1834 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Агар од инженеринг” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ